

## **2020 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2020 оны 1 дүгээр сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 6 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ ирүүлсэн. ГССҮТ, УАУХТ эмнэлгүүдээс мэдээ ирээгүй.

### **Нэг. Амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2020 оны 1 дүгээр сард 575 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, амбулаторийн хүлээгдлийн 666 тохиолдол бүртгэгдсэн байна. Тухайлбал:

УНТЭ 17 хүлээгдэл, УХТЭ 39 хүлээгдэл, УГТЭ 35 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна. Харин ЭХЭМҮТ, СЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй ажиллажээ.

Амбулаторийн хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

**УНТЭ**-ийн амбулаторийн есөн кабинетэд 17 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сар буюу 2019 оны 12-р сард 158 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэнээс 141 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан харагдаж байна. Үүнд: Бөөрний кабинет 2, зүрх судасны кабинет 1, уушигны кабинет 1, мэдрэлийн кабинет 2, нүдний кабинет 1, чих хамар хоолойн кабинет 3, урологийн кабинет 1, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 5, эрүү нүүрний мэс заслын кабинет 1 хүлээгдэл тус бүр 2-6 хоногийн хугацаатай хүлээсэн байна.


**УХТЭ**-г нийт 9 кабинетэд 39 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын амбулаторийн хүлээгдлээс 32 хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Бөөр судлалын кабинет 8, зүрх судасны кабинет 6, уушигны кабинет 6, мэдрэл судлалын кабинет 2, нүдний кабинет 3, нүдний даралтын кабинет 3, урологийн кабинет 3, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 4, эмэгтэйчүүдийн кабинет 4 үйлчлүүлэгч тус тус 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө 149 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

**УГТЭ**-ийн 2 кабинетэд нийт 35 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 75 хүлээгдлээр буурсан харагдаж байна. Үүнд:

Зүрх судасны кабинетэд 26, уушигны кабинет 9 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 426 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 2020 оны 1-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:




Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн амбулаторийн хүлээгдлийн түвшинг кабинетаар авч үзвэл: УГТЭ-ийн зүрх судасны кабинетын хүлээгдэл 26 буюу хамгийн их хүлээгдэлтэй, УНТЭ-ийн зүрх судасны кабинетын 1 буюу хамгийн бага хүлээгдэлтэй, УНТЭ-ийн бөөрний кабинетын хүлээгдэл 2 буюу хамгийн бага хүлээгдэлтэй, УГТЭ-ийн бөөрний кабинетын хүлээгдэл 10 буюу хамгийн бага хүлээгдэлтэй, УНТЭ-ийн уушигны кабинетын хүлээгдэл 1 буюу хамгийн бага, УГТЭ-ийн уушигны кабинетын хүлээгдэл 16 буюу хамгийн их хүлээгдэлтэй байна.

### Хоёр. Оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2020 оны 1 дүгээр сард 337 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн ба УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетуудад 191 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 147 хүлээгдлээр буурсан харагдаж байна.




Оношлогооны хүлээгдлийг хоногоор авч үзвэл:



Оношлогооны хүлээгдэл УГТЭ 69 буюу хамгийн их, УНТЭ 23 буюу хамгийн бага хүлээгдэлтэй байна. УХТЭ өдөртөө 137 үйлчлүүлэгч буюу их үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.


УНТЭ-ийн оношилгооны хүлээгдлийг кабинетаар авч үзвэл:



УНТЭ-ийн оношлогооны нийт хүлээгдэл 23 ба өмнөх сарын хүлээгдлээс 10 хүлээгдлээр нэмэгдсэн байна.


**УХТЭ**-г 76 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, рентген зураг, зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн ЭХО харах шинжилгээнд оношлуулахаар 35 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд:

Рентген зураг 8, зүрхний цахилгаан бичлэг 11, хэвлийн эхо 11, холтер 1, ЭЭГ 3, MRI 1 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-6 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.




УХТЭ-ийн 1-р сарын хүлээгдэл 35 буюу өмнөх сарын хүлээгдлээс 34 хүлээгдлээр буурсан байна.

**УГТЭ**-т 137 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, рентген зураг, зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн ЭХО харах шинжилгээнүүдэд оношлуулахаар 69 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Рентген зураг 10, зүрхний цахилгаан бичлэг 33, хэвлийн эхо 26 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.



УГТЭ-ийн оношлогооны нийт хүлээгдэл 69 буюу өмнөх сарын хүлээгдлээс 23 хүлээгдлээр нэмэгдсэн байна.

**СЭМҮТ**-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 64 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 124 өдөртөө, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 64 үйлчлүүлэгч байна.



СЭМҮТ-ийн ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний хүлээгдэл 64 буюу өмнөх сарын хүлээгдлээс 30 хүлээгдлээр нэмэгдсэн байна.

**ЭХЭМҮТ**-д оношилгооны хүлээгдэлгүй ажилласан байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетийн 12, 1-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:

№	Оношилгооны хүлээгдэл	УНТЭ		УХТЭ		УГТЭ		СЭМҮТ		Нийт	
		12 сар	1 сар	12 сар	1 сар	12сар	1 сар	12 сар	1 сар	12 сар	1 сар
1	Рентген зураг	2	2	57	8	28	10			87	20
2	ЭЭГ				3						3
3	Зүрхний ЭХО	5	5							5	5
4	MRI			1	1					1	1
5	ЭКГ	1	1	4	11	35	33			40	45
6	Хэвлийн ЭХО	3	3	7	11	29	26			39	40
7	Холтер	1			1					1	1
8	Эмгэг сэтгэл судлал							34	64	34	64
9	Зүрхний ачаалалтай сорил		1								1
10	Урологийн оношилгооны дуран		1								1
11	КТГ	1	10							1	10
12	<b>Нийт</b>	<b>13</b>	<b>23</b>	<b>69</b>	<b>35</b>	<b>92</b>	<b>69</b>	<b>34</b>	<b>64</b>	<b>208</b>	<b>191</b>

**Дүгнэлт:** Нийт оношлогооны хүлээгдэл 191 буюу өмнөх сарын хүлээгдлээс 17 хүлээгдлээр буурсан байна. Оношлогооны хүлээгдлийг кабинетаар авч үзвэл:

Рентген зураг авах шинжилгээ 20 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй буюу өмнөх сарын хүлээгдлээс 67 хүлээгдлээр буурсан байна. ЭКГ 45 буюу өмнөх сарын хүлээгдлээс 5 хүлээгдлээр, хэвлийн ЭХО 40 буюу өмнөх сарын хүлээгдлээс 1 хүлээгдлээр, эмгэг сэтгэл судлал 64 буюу өмнөх сарын хүлээгдлээс 30 хүлээгдлээр, КТГ 10 хүлээгдэл буюу өмнөх сарын хүлээгдлээс 9 хүлээгдээр тус тус нэмэгдсэн байна.

### **Гурав. Лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**

2020 оны 1 дүгээр сард УНТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан байна.

**УХТЭ**-т лабораторийн шинжилгээний хүлээгдэл бүртгэгдсэнийг дүгнэхэд: 474 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн ба лабораторид шинжилгээ өгөхөөр 182 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 127 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

Цусны ерөнхий шинжилгээ 5, шээсний ерөнхий шинжилгээ 4, биохимийн шинжилгээ 31, бактериологийн шинжилгээ 3, иммунологийн шинжилгээ 9, серологийн шинжилгээ 3, коагулограммын шинжилгээнд 1 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

**УГТЭ**-г 255 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, 126 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлж өмнөх сарын хүлээгдлээс 13 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:


Цусны ерөнхий шинжилгээ 59, биохимийн шинжилгээ 67 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Шээсний ерөнхий шинжилгээ, бактериологи, серологи, цитологи, иммунологи, коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

УХТЭ, УГТЭ-үүдийн 2019 оны 12-р сар, 2020 оны 1-р сарын лабораторын шинжилгээний хүлээгдлийн мэдээ

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	УХТЭ		УГТЭ		Нийт	
			12 сар	1 сар	12 сар	1 сар	12 сар	1 сар
1	Цусны шинжилгээ	Өдөртөө	24	19	30	27	54	46
		1 хоног	45	25	37	32	82	57
		2 хоног	2	4	38	35	40	39
		3-6 хоног	2	1	28	24	30	25
		7-14хоног					0	0
		15ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>66</b>	<b>59</b>	<b>70</b>	<b>64</b>
2	Шээсний шинжилгээ	Өдөртөө	19	19	45	45	64	64
		1 хоног	37	24	41	34	78	58
		2 хоног	3	3			3	3
		3-6 хоног		1			0	1
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>4</b>
3	Биохими	Өдөртөө	221	149	43	49	264	198
		1 хоног	434	203	45	43	479	246
		2 хоног	23	20	40	38	63	58
		3-6 хоног		11	33	29	33	40
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>23</b>	<b>31</b>	<b>73</b>	<b>67</b>	<b>96</b>	<b>98</b>
4	Бактерлоги	Өдөртөө	1	8	32	41	33	49
		1 хоног	12	11			12	11
		2 хоног	3	2			3	2
		3-6 хоног		1			0	1
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>3</b>
5	Иммунологи	Өдөртөө	1	15	25	24	26	39
		1 хоног	3	31	24	35	27	66
		2 хоног	15	7			15	7
		3-6 хоног	5	2			5	2
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>20</b>	<b>9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>20</b>	<b>9</b>

6	Серлоги	Өдөртөө	5	2	22	27	27	29
		1 хоног		4			0	4
		2 хоног		3			0	3
		3-6 хоног					0	0
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
7	Цитологи	Өдөртөө	1	1			1	1
		1 хоног	4	2			4	2
		2 хоног					0	0
		3-6 хоног					0	0
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
8	Коагулограм М	Өдөртөө	1	6	38	42	39	48
		1 хоног		6			0	6
		2 хоног		1			0	1
		3-6 хоног	2				2	0
		7-14хоног					0	0
		15 ба түүнээс дээш					0	0
		<b>Бүгд</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>2</b>
9	Хүлээгдэл		55	56	139	126	194	182
10	өдөртөө үйлчлүүлсэн		273	219	235	255	508	474
11	Нийт		328	275	374	381	702	656
12	Хоногоор	Өдөртөө	273	219	235	255	508	474
		1 хоног	535	306	147	144	682	450
		2 хоног	46	40	78	73	124	113
		3-6 хоног	9	16	61	53	70	69
		7-14хоног	0	0	0	0	0	0
		15 ба түүнээс дээш	0	0	0	0	0	0
		2-оос дээш хоногийн хүлээгдэл	55	56	139	126	194	182




## Дөрөв. Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2020 оны 1 дүгээр сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, НЭМГ-ын харьяа ЭМБ-ууд бүртгэн мэдээлснийг дүгнэхэд:

УНТЭ, ЭХЭМҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгууд хүлээгдэлгүй ажилласан байна.

УХТЭ, УГТЭ, СЭМҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгуудад 3-6 хоногийн хүлээгдэлтэй 175 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 175 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 119 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 25 үйлчлүүлэгч нийт 494 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн байна.

Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг хоногоор авч үзвэл:



УХТЭ-т 1-р сард 3-6 хоногийн хүлээгдэлтэй 77, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 109, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 59 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд:

Бөөрний тасагт 16, зүрх судасны системийн тасагт 34, уушигны тасагт 18, мэс заслын тасагт 134, мэдрэлийн тасагт 10, уламжлалт эмчилгээний тасагт 20, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 13 үйлчлүүлэгч байна.


УГТЭ-т 1-р сард 57 үйлчлүүлэгч 3-6 хоног, 66 үйлчлүүлэгч 7-14 хоног, 60 үйлчлүүлэгч 15-30 хоног, 25 үйлчлүүлэгч 1 сараас дээш хоног хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. Үүнд:

Бөөрний тасагт 15, зүрх судасны тасагт 17, уушигны тасагт 13, мэдрэлийн тасагт 16, чих хамар хоолойн тасагт 40, уламжлалт эмчилгээний тасагт 6, мэдрэлийн мэс засалд 95, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 4, зүрхний мэс засалд 2, үйлчлүүлэгч тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Эндээс харахад мэдрэлийн мэс заслын тасаг хамгийн олон хоногийн хүлээгдэлтэй ажилласан байна.

СЭМҮТ-ийн 1-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт 41 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.



СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (сүүлийн 6 сарын байдлаар)



**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2020 оны 1-р сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	1 дүгээр сар										
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	20	11	0	7	8	47	0	9	0	0	0
		1-3 хоног		7		2		3		5			
		3-6 хоног	8	4		4	1	8		4			
		7-14хоног	12			1	2	19					
		15-30 хоног					5	17					
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	23	12	12	49	12	49	151	18	0	0	0
		1-3 хоног		6	6	17		5	51	10			
		3-6 хоног		6	3	9	6	6	55	8			
		7-14хоног	23		3	12	6	24	25				
		15-30 хоног				11		14	20				
		1 сараас дээш											
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	128	0	0	0	0	24	0	0	0	0	0
		1-3 хоног	23										
		3-6 хоног	32										
		7-14хоног	43					24					
		15-30 хоног	30										
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	0	0	0	0	0	13	0	0	0	0	0


		1-3 хоног							4					
		3-6 хоног												
		7-14хоног							5					
		15-30 хоног							4					
		1 сараас дээш												
6	Нарколог-ийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	74
		1-3 хоног												25
		3-6 хоног												17
		7-14хоног												32
		15-30 хоног												
		1 сараас дээш												

НЭМГ-ын харьяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл БГДЭМТ-ийн мэдрэл 47, дотор 49, БЗДНЭ-ийн дотор 151, НДЭМТ-ийн дотор 49, СХДЭМТ-ийн ахмадын эмнэлэг 71 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилжээ.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 1-р сард 39812 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 9349 дуудлагаар нэмэгдсэн байна. Нийт дуудлагын 33.4%-ийг 0-20 минутад, 29.8%-ийг 21-40 минутад, 17.6%-ийг 41-60 минутад, 19.2%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 1 дүгээр сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 0.2%-иар буурсан, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 1.8%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019-2020 оны сүүлийн 6 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

### МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА

